



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Чулуут сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2022/143/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Архангай аймаг

2022 он

Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа

Утас: 7033-3141

Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn

Аудитын менежер Д.Нэргүйбаатар

Утас: 7033-2860

Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn

Аудитор Л.Соёлмөнх

Цахим хаяг: Soyolmunkhl@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

| | |
|--|-----------|
| 1.Аудитын санал, дүгнэлт | |
| 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл | 4 |
| 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан | 4 |
| 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан | 5 |
| 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан | 6 |
| 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан..... | 7 |
| 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан | 8 |
| 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан..... | 10 |
| 3. Аудитын тайлан..... | 11 |
| 3.1 Ерөнхий зүйл..... | 11 |
| 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт | 11 |
| 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал | 12 |
| 3.4 Материаллаг байдал | 13 |
| 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга | 13 |
| 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв..... | 14 |
| 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг | 15 |
| 3.8 Аудитын гол асуудал | 16 |
| 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал | 16 |
| 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт..... | 16 |
| 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт | 17 |
| 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал..... | 17 |
| 4. Аудитын илрүүлэлт | 17 |
| 4.1 Залруулсан алдаа | 17 |
| 4.2 Төлбөрийн акт | 18 |
| 4.3 Албан шаардлага | 18 |
| 4.4 Зөвлөмж | 18 |
| 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл | 19 |

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|----------|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТЕЗ | Төсвийн Ерөнхийлөн захирагч |
| ЭМДС | Эрүүл мэндийн даатгалын сан |



**АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

65130 Цэцэрлэг, Архангай аймаг

Утас/Факс: 976-70333141

И-мэйл: arkhangai@audit.gov.mn

2022.02.25 № 100

танай _____ -ны № _____ -т

ЧУЛУУТ СУМЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГА Ё.ДУЛАМСҮРЭН ТАНАА

Аудитын санал дүгнэлт

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн Чулуут сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Архангай аймгийн Чулуут сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Тайлант онд Чулуут сумын Эрүүл мэндийн төв нь 22.1 сая төгрөгийн авлага үүсгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалтыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Т.БАЙГАЛМАА



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021.12.31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|--------------|---|-----------------------|-----------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 60,820,677.03 | 267,846,989.38 |
| 33 | АВЛАГА | 0.00 | 106,663,400.00 |
| 33200 | Төлбөртэй үйлчилгээний авлага | 0.00 | 84,542,700.00 |
| 33500 | Бусад авлага | 0.00 | 22,120,700.00 |
| 33510 | Байгууллагаас авах авлага | 0.00 | 22,120,700.00 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 60,820,677.03 | 161,183,589.38 |
| 35100 | Түүхий эд материал | 25,304,501.03 | 109,087,763.38 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 6,261,050.00 | 14,360,700.49 |
| 35130 | Эм боох материал | 19,043,451.03 | 94,727,062.89 |
| 35400 | Хангамжийн материал | 35,516,176.00 | 52,095,826.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,016,550.00 | 3,488,900.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 28,038,036.00 | 41,750,106.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 560,000.00 | 1,330,000.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 4,669,620.00 | 3,541,465.00 |
| 35460 | Хүнсний материал | 1,231,970.00 | 1,487,855.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 0.00 | 497,500.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 468,060,586.18 | 539,845,892.50 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 468,060,586.18 | 539,845,892.50 |
| 39200 | Биет хөрөнгө | 455,492,586.18 | 527,277,892.50 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 430,107,275.65 | 430,107,275.65 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -77,437,990.28 | -79,577,972.18 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 115,489,158.00 | 166,192,344.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -65,206,839.69 | -68,809,246.66 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 122,718,786.58 | 83,826,588.45 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -88,573,407.27 | -22,121,091.77 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 22,859,281.00 | 22,859,281.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -8,725,649.81 | -9,461,257.99 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 4,346,230.00 | 4,346,230.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -84,258.00 | -84,258.00 |
| 39300 | Биет бус хөрөнгө | 12,568,000.00 | 12,568,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 12,568,000.00 | 12,568,000.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 528,881,263.21 | 807,692,881.88 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 528,881,263.21 | 807,692,881.88 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 528,881,263.21 | 807,692,881.88 |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 238,055,180.58 | 238,055,180.58 |
| 51200 | Хуримтлагдсан үр дүн | 156,687,848.32 | 435,499,466.99 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 108,608,063.15 | 156,687,848.32 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 48,079,785.17 | 278,811,618.67 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 134,138,234.31 | 134,138,234.31 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 528,881,263.21 | 807,692,881.88 |

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---------------|--|-----------------------|-------------------------|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 533,217,145.91 | 1,268,868,093.87 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 76,083,785.91 | 315,373,823.87 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 76,083,785.91 | 315,373,823.87 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 42,356,661.91 | 0.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 42,356,661.91 | 0.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 33,727,124.00 | 66,457,260.22 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 0.00 | 248,916,563.65 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 457,133,360.00 | 953,494,270.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 407,269,500.00 | 461,257,600.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 407,269,500.00 | 461,257,600.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 876,100.00 | 441,335,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 876,100.00 | 356,792,300.00 |
| 131107 | Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого | 0.00 | 84,542,700.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 10,025,700.00 | 11,627,300.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 10,025,700.00 | 11,627,300.00 |
| 1340 | Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих | 38,962,060.00 | 39,274,370.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 38,962,060.00 | 39,274,370.00 |
| II | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 485,137,360.74 | 990,056,475.20 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 485,137,360.74 | 990,056,475.20 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 485,137,360.74 | 955,056,475.20 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 319,148,963.63 | 546,835,600.00 |
| 210101 | Үндсэн цалин | 213,938,006.13 | 226,028,392.00 |
| 210102 | Нэмэгдэл | 78,884,914.50 | 248,166,860.79 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 6,026,043.00 | 0.00 |
| 210104 | Урамшуулал | 20,300,000.00 | 40,565,000.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 0.00 | 32,075,347.21 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 36,446,536.37 | 50,496,200.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 24,992,636.37 | 35,534,300.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,888,800.00 | 3,740,500.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,311,100.00 | 2,992,400.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 577,800.00 | 748,100.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,676,200.00 | 7,480,900.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 5,447,400.00 | 11,881,300.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,450,000.00 | 3,832,756.00 |
| 210302 | Түлш, халаалт | 2,911,000.00 | 8,008,544.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 86,400.00 | 40,000.00 |
| 210304 | Байрны түрээс | 0.00 | 0.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 27,297,385.00 | 47,569,446.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,747,300.00 | 3,880,950.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 19,704,995.00 | 32,883,655.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,519,500.00 | 3,241,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 368,950.00 | 2,162,080.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,956,640.00 | 5,401,761.00 |
| 2105 | Нормативт зардал | 46,674,040.88 | 275,435,236.30 |

| | | | |
|-------------|--|----------------------|-----------------------|
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 40,334,630.88 | 257,022,121.30 |
| 210502 | Хоол, хүнс | 5,162,310.00 | 16,894,115.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,177,100.00 | 1,519,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 1,451,300.00 | 6,061,905.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 761,000.00 | 4,714,005.00 |
| 210604 | Урсгал засвар | 690,300.00 | 1,347,900.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 1,600,000.00 | 3,300,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,600,000.00 | 3,300,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 35,919,495.00 | 226,584.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 34,819,495.00 | 0.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 250,000.00 | 0.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 40,000.00 | 108,900.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 60,000.00 | 117,684.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 750,000.00 | 0.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 11,152,239.86 | 13,250,203.90 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 3,665,500.00 | 4,846,200.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 7,486,739.86 | 8,404,003.90 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 0.00 | 35,000,000.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 0.00 | 35,000,000.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 0.00 | 35,000,000.00 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II) | 48,079,785.17 | 278,811,618.67 |
| VI | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V) | 48,079,785.17 | 278,811,618.67 |

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|-----|---------------------------------------|---------------------------------|-----------------------|-------------------|---|
| 1 | 2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 238,055,180.58 | 134,138,234.31 | 108,608,063.15 | 480,801,478.04 |
| 3 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 238,055,180.58 | 134,138,234.31 | 108,608,063.15 | 480,801,478.04 |
| 9 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | 48,079,785.17 | 48,079,785.17 |
| 10 | 2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 238,055,180.58 | 134,138,234.31 | 156,687,848.32 | 528,881,263.21 |
| 11 | 2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 238,055,180.58 | 134,138,234.31 | 156,687,848.32 | 528,881,263.21 |
| 13 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 238,055,180.58 | 134,138,234.31 | 156,687,848.32 | 528,881,263.21 |
| 19 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | 278,811,618.67 | 278,811,618.67 |
| 20 | 2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл | 238,055,180.58 | 134,138,234.31 | 435,499,466.99 | 807,692,881.88 |

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|-------------|--|-----------------------|-----------------------|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I) | 457,133,360.00 | 868,951,570.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 457,133,360.00 | 868,951,570.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 407,269,500.00 | 461,257,600.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 407,269,500.00 | 461,257,600.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 876,100.00 | 356,792,300.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 876,100.00 | 356,792,300.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 10,025,700.00 | 11,627,300.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 10,025,700.00 | 11,627,300.00 |
| 1340 | Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих | 38,962,060.00 | 39,274,370.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 38,962,060.00 | 39,274,370.00 |
| II | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 457,133,360.00 | 855,219,520.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 457,133,360.00 | 855,219,520.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 457,133,360.00 | 820,219,520.00 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 313,300,000.00 | 546,835,600.00 |
| 210101 | Үндсэн цалин | 197,671,394.50 | 215,831,521.00 |
| 210102 | Нэмэгдэл | 88,998,905.50 | 258,363,731.79 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 6,329,700.00 | 0.00 |
| 210104 | Урамшуулал | 20,300,000.00 | 40,565,000.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 0.00 | 32,075,347.21 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 42,295,500.00 | 50,496,200.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 29,763,500.00 | 35,534,300.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,133,000.00 | 3,740,500.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,506,400.00 | 2,992,400.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 626,600.00 | 748,100.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,266,000.00 | 7,480,900.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 9,136,900.00 | 13,727,300.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,450,000.00 | 3,832,756.00 |
| 210302 | Түлш, халаалт | 6,600,500.00 | 9,854,544.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 86,400.00 | 40,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 22,279,765.00 | 49,085,500.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,003,000.00 | 5,526,900.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 16,007,265.00 | 28,909,500.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,519,500.00 | 3,317,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 500,000.00 | 3,132,100.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,250,000.00 | 8,200,000.00 |
| 2105 | Нормативт зардал | 24,334,200.00 | 114,614,020.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 16,155,100.00 | 93,264,020.00 |
| 210502 | Хоол, хүнс | 5,750,000.00 | 17,150,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,429,100.00 | 4,200,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 888,800.00 | 30,862,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 0.00 | 24,462,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 888,800.00 | 6,400,000.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 1,600,000.00 | 3,300,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,600,000.00 | 3,300,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 35,919,495.00 | 198,900.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 34,819,495.00 | 0.00 |

| | | | |
|-------------|---|---------------------|-----------------------|
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 250,000.00 | 0.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 40,000.00 | 108,900.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 60,000.00 | 90,000.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 750,000.00 | 0.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 7,378,700.00 | 11,100,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 7,378,700.00 | 11,100,000.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 0.00 | 35,000,000.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 0.00 | 35,000,000.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 0.00 | 35,000,000.00 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II) | 0.00 | 13,732,050.00 |
| V | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V) | 0.00 | 13,732,050.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 0.00 | 13,732,050.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 0.00 | 13,732,050.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 0.00 | 13,732,050.00 |
| VI | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V) | 0.00 | -13,732,050.00 |
| VII | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН | 0.00 | 0.00 |
| VIII | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII) | 0.00 | 0.00 |

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|-------------|---|-----------------------|-----------------------|---------------------|---------------|
| II | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 515,474,600.00 | 512,159,270.00 | 3,315,330.00 | 99.36 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 515,474,600.00 | 512,159,270.00 | 3,315,330.00 | 99.36 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 515,474,600.00 | 512,159,270.00 | 3,315,330.00 | 99.36 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 374,045,100.00 | 374,045,100.00 | 0.00 | 100.00 |
| 210101 | Үндсэн цалин | 203,000,000.00 | 203,000,000.00 | 0.00 | 100.00 |
| 210102 | Нэмэгдэл | 97,000,000.00 | 98,404,752.79 | -1,404,752.79 | 101.45 |
| 210104 | Урамшуулал | 40,565,000.00 | 40,565,000.00 | 0.00 | 100.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 33,480,100.00 | 32,075,347.21 | 1,404,752.79 | 95.80 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 50,496,200.00 | 50,496,200.00 | 0.00 | 100.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 35,534,300.00 | 35,534,300.00 | 0.00 | 100.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,740,500.00 | 3,740,500.00 | 0.00 | 100.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,992,400.00 | 2,992,400.00 | 0.00 | 100.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 748,100.00 | 748,100.00 | 0.00 | 100.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 7,480,900.00 | 7,480,900.00 | 0.00 | 100.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 10,027,300.00 | 10,027,300.00 | 0.00 | 100.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,897,300.00 | 3,099,232.00 | -201,932.00 | 106.97 |
| 210302 | Түлш, халаалт | 7,000,000.00 | 6,888,068.00 | 111,932.00 | 98.40 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 130,000.00 | 40,000.00 | 90,000.00 | 30.77 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 28,306,000.00 | 28,306,000.00 | 0.00 | 100.00 |

Чулуут сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

| | | | | | |
|-------------|---|-----------------------|-----------------------|---------------------|---------------|
| 210401 | Бичиг хэрэг | 2,300,000.00 | 2,300,000.00 | 0.00 | 100.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 18,100,000.00 | 18,100,000.00 | 0.00 | 100.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,856,000.00 | 2,856,000.00 | 0.00 | 100.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,500,000.00 | 1,500,000.00 | 0.00 | 100.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,550,000.00 | 3,550,000.00 | 0.00 | 100.00 |
| 2105 | Нормативт зардал | 34,000,000.00 | 31,686,520.00 | 2,313,480.00 | 93.20 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 24,000,000.00 | 23,086,520.00 | 913,480.00 | 96.19 |
| 210502 | Хоол, хүнс | 7,500,000.00 | 7,500,000.00 | 0.00 | 100.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,500,000.00 | 1,100,000.00 | 1,400,000.00 | 44.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 5,100,000.00 | 5,099,250.00 | 750.00 | 99.99 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 3,500,000.00 | 3,499,250.00 | 750.00 | 99.98 |
| 210604 | Урсгал засвар | 1,600,000.00 | 1,600,000.00 | 0.00 | 100.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 3,300,000.00 | 3,300,000.00 | 0.00 | 100.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 3,300,000.00 | 3,300,000.00 | 0.00 | 100.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,200,000.00 | 198,900.00 | 1,001,100.00 | 16.58 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 250,000.00 | 0.00 | 250,000.00 | 0.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 110,000.00 | 108,900.00 | 1,100.00 | 99.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 90,000.00 | 90,000.00 | 0.00 | 100.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 750,000.00 | 0.00 | 750,000.00 | 0.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 9,000,000.00 | 9,000,000.00 | 0.00 | 100.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 9,000,000.00 | 9,000,000.00 | 0.00 | 100.00 |
| III | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 515,474,600.00 | 512,159,270.00 | 3,315,330.00 | 99.36 |
| 31 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 461,257,600.00 | 461,257,600.00 | 0.00 | 100.00 |
| 310003 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 461,257,600.00 | 461,257,600.00 | 0.00 | 100.00 |
| 32 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 11,627,300.00 | 11,627,300.00 | 0.00 | 100.00 |
| 320001 | Орон нутгийн төсвөөс | 11,627,300.00 | 11,627,300.00 | 0.00 | 100.00 |
| 33 | НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 42,589,700.00 | 39,274,370.00 | 3,315,330.00 | 92.22 |
| 330002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 42,589,700.00 | 39,274,370.00 | 3,315,330.00 | 92.22 |
| 61 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | 1 | 1 | 0.00 | 100.00 |
| 610001 | Төсвийн байгууллага | 1 | 1 | 0.00 | 100.00 |
| 62 | АЖИЛЛАГСАДЫН ТОО | 25 | 25 | 0.00 | 100.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 1 | 1 | 0.00 | 100.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 19 | 19 | 0.00 | 100.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 5 | 5 | 0.00 | 100.00 |

2.5 Нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|-------------|--|-----------------------|
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0.00 |
| I | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 356,792,300.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 344,935,500.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 309,935,500.00 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 172,790,500.00 |
| 210101 | Үндсэн цалин | 12,831,521.00 |
| 210102 | Нэмэгдэл | 159,958,979.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 3,700,000.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 733,524.00 |
| 210302 | Түлш, халаалт | 2,966,476.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 20,779,500.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,226,900.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 10,809,500.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 461,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,632,100.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,650,000.00 |
| 2105 | Нормативт зардал | 82,927,500.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 70,177,500.00 |
| 210502 | Хоол, хүнс | 9,650,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 3,100,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 27,638,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 22,838,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 4,800,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,100,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,100,000.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 35,000,000.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 35,000,000.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 35,000,000.00 |
| II | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 356,792,300.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 356,792,300.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 356,792,300.00 |
| IV | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I) | 0.00 |

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Чулуут сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Л.Соёлмөнх гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Нэргүйбаатар, дарга, тэргүүлэх аудитор Т.Байгалмаа нар тус тус хэрэгжүүлсэн.

Чулуут сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 04 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Чулуут сумын Эрүүл мэндийн төв нь хүн амыг эрүүл амьдрах дадал зан төлөвийг хэвшүүлэн амьдралын насжилтыг /дундаж наслалт/ уртасгах алсын харааг тодорхойлж, хөдөөгийн хүн амд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг чанартай, аюулгүй үзүүлж, хүн амын эрүүл мэндийн боловсролын дээшлүүлснээр эрүүл амьдрах, насжилтыг уртасгах, үүний тулд нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд тэргүүлэх ач холбогдол өгч ажиллах зорилготой нийгмийн болон эмнэлгийн эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг хүргэх чиг үүрэг бүхий аймгийн ТЕЗ-ийн харьяа тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллага байна.

Тус байгууллага нь тайлант онд дараах зорилтуудыг тавин ажилласан байна. Үүнд:

- ✓ Чанар аюулгүй байдлын удирдлага зохион байгуулалтыг боловсронгуй болгох, тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлыг тасралтгүй хэмжиж сайжруулах
- ✓ Чанар сайжруулах хэрэгсэл нэвтрүүлж хэрэгжүүлэх түгээн дэлгэрүүлэх
- ✓ Хүний нөөцийн чадварыг бэхжүүлэх
- ✓ Нотолгоонд суурилсан анагаах ухааныг хөгжүүлэх
- ✓ Үйлчлүүлэгч төвтэй тусламж үйлчилгээг хөгжүүлэх
- ✓ ЭМТҮ-тэй холбоотой халдвараас сэргийлэнх хянах тогтолцоог сайжруулах
- ✓ Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангах эрсдэлийг бууруулах.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- “Нийгмийн даатгалын сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль”-иар нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээ өөрчлөгдсөн.

- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”
- Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан 67/А/268, А/387/99 дугаар тушаал “Коронавируст халдвар /Ковид-19/-ын эсрэг эрүүл мэндийн цогц тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх журам, тусламж үйлчилгээний багц, төлбөрийн хэмжээ батлах тухай”
- Эрүүл мэндийн Сайдын 2021 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн А/496 дугаар тушаал “Нэг удаагийн мөнгөн тэтгэмж олгох тухай”
- Эрүүл мэндийн Сайдын 2021 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн А/605 дугаар тушаал “Журам, аргачлал батлах тухай”
- Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/585 дугаар тушаал “Мөнгөн тэтгэмж олгох тухай”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Чулуут сумын Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаанд дотоод хяналтыг хэрэгжүүлэн ажилласан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тус байгууллагын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккурэль сууриар хөтөлсөн, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу хөтөлбөр, арга хэмжээгээр бэлтгэж, тайлбар танилцуулгын хамт ирүүлсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдлийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 515.4 сая төгрөгөөс 1 хувиар буюу 5.1 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувь буюу 3.8 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг төлөвлөлтийн шатны ерөнхий материаллаг байдлыг хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Тус байгууллагын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаар нийт хөрөнгийн дүн эхний үлдэгдлээс 54.3 хувиар өссөн материаллаг өөрчлөлт гарсан нь авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүү байдлын тайлангийн үзүүлэлт

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | /сая төгрөгөөр/ | |
|---|----------------|-----------------|-----------------|--------------|
| | | | Өөрчлөлт | хувь |
| Авлага | - | 106.7 | 106.66 | - |
| Бараа материал | 60.82 | 161.18 | 100.36 | 165.01 |
| Үндсэн хөрөнгө | 468.06 | 548.25 | 80.19 | 17.13 |
| Нийт хөрөнгө | 528.88 | 816.09 | 287.21 | 54.31 |
| Өр төлбөр | | 0 | - | |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 528.88 | 816.09 | 287.21 | 54.31 |
| Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн | 528.88 | 816.09 | 287.21 | 54.31 |

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Авлагын дансны үлдэгдэл тайлант онд нийт 106.66 сая төгрөгөөр өссөний 84.5 сая төгрөг нь ЭМДС-аас авах ковидын цогц тусламж үйлчилгээний санхүүжилт нэхэмжилснээс дутуу ирсэнтэй холбоотой, 22.12 сая төгрөг нь оны эцэст үндсэн хөрөнгө худалдан авахаар төлбөрийг урьдчилан шилжүүлж байгууллагаас авах авлага үүссэнтэй холбоотой байна.
- Бараа материал эхний үлдэгдлээс 165.0 хувиар өссөн байна.

Бараа материалын данс нь 60.8 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 182.9 сая төгрөг, хандиваар 248.9 сая төгрөг, нийт 431.8 сая төгрөгөөр нэмэгдэж, тайлант онд 331.4 сая төгрөгийн бараа материалыг зарцуулан оны эцэст 161.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Үндсэн хөрөнгө эхний үлдэгдлээс 17.1 хувиар өссөн байна.

Үндсэн хөрөнгө данс нь 708.0 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд 13.7 сая төгрөгийн компьютер, тоног төхөөрөмж худалдан авсан, аймгийн Эрүүл мэндийн газраас 66.4 сая төгрөгийн хандив тусламж өгснийг данс бүртгэлд тусгаж, нийт 80.1 сая төгрөгөөр үндсэн хөрөнгө нэмэгдэж, 68.3 сая төгрөгөөр хөрөнгийг актлаж данснаас хассан, тайлант хугацаанд байгуулсан 171.6 сая төгрөгийн элэгдлээр буурч, 548.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Цэвэр хөрөнгө өмчийн дүн 287.2 сая төгрөгөөр өссөн нь тайлант хугацааны үр дүнтэй шууд холбоотой бөгөөд тайлант хугацаанд 287.2 сая төгрөгийн үр дүнг хүлээн зөвшөөрсөн байна.

Хүснэгт 2. Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үзүүлэлт

| Үзүүлэлт | /сая төгрөгөөр/ | | |
|--|-----------------|-----------------|---------------|
| | Өмнөх он | Тайлант он | Өөрчлөлт |
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 76.96 | 315.37 | 238.41 |
| Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 407.27 | 461.25 | 53.98 |
| Нэмэлт санхүүжилт | 0.00 | 441.34 | 441.34 |
| Орон нутгийн төсвөөс | 10.02 | 11.63 | 1.61 |
| Эрүүл мэндийн даатгалын сангаас | 38.96 | 39.27 | 0.31 |
| Үйл ажиллагааны орлого | 533.21 | 1,268.86 | 735.65 |
| Цалин, шимтгэлийн зардал | 355.58 | 597.32 | 241.74 |
| Бараа ажил үйлчилгээний зардал | 82.48 | 344.27 | 261.79 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 35.92 | 0.22 | (35.70) |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 11.15 | 4.84 | (6.31) |
| Урсгал шилжүүлэг | 0.00 | 35.00 | 35.00 |
| Хөрөнгийн зардал | | | - |
| Үйл ажиллагааны зардал | 485.13 | 981.65 | 496.52 |
| ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V) | 48.08 | 287.21 | 239.13 |

Чулуут сумын Эрүүл мэндийн төвийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны орлого өмнөх оноос 735.6 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд ковид-19-ын эсрэг эрүүл мэндийн цогц тусламж үйлчилгээний санхүүжилтийг Эрүүл мэндийн даатгалын сангаас олгосон, мөн үнэ төлбөргүй хүлээн авсан орлого өссөнтэй холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 461.0 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг нийт 54.4 сая төгрөгөөр нэмэгдүүлж, нийт зардлыг 515.4 сая төгрөгөөр хянаж баталсан бол тодотголоор батлагдсан төсөвт өөрчлөлт ороогүй байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагч 2 хөтөлбөрийн 3 арга хэмжээг хэрэгжүүлэхэд 515.4 сая төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 3.3 сая төгрөгийн санхүүжилт Эрүүл мэндийн даатгалын сангаас дутуу авсан байна. Тайлант онд 512.1 сая төгрөгийн

санхүүжилтийг авч, бүрэн зарцуулсан бөгөөд мөнгөн хөрөнгийн үлдэгдэлгүй тайлагнагдсан байна. Энэ нь Эрүүл мэндийн салбарын шинэчлэлийн хүрээнд гүйцэтгэлээр санхүүжүүлэх болсонтой холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар ЭМДС-аас ковид-19-ын эсрэг эрүүл мэндийн цогц тусламж үйлчилгээний санхүүжилт 321.7 сая төгрөг, Эрүүл мэндийн сайдын А/496, А/585 дугаар тушаалын дагуу коронавируст халдварын эрсдлээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээнд ажилласан эрүүл мэндийн салбарын ажилтнуудыг урамшуулах зорилгоор олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжид 35.0 сая төгрөг, нийт 356.7 сая төгрөгийн орлого төвлөрсөн байна. Ирсэн санхүүжилтийг зарцуулах эрхийн хүсэлт нээлгэн зарцуулсан бөгөөд цалин шимтгэлд 172.8 сая, байр ашиглалтын зардалд 3.7 сая, хангамж бараа материалын зардалд 20.8 сая, эмийн зардалд 70.2 сая, хоол хүнсэнд 9.6 сая, нормын хувцас зөөлөн эдлэлд 3.1 сая, багаж техник хэрэгсэлд 22.8 сая, урсгал зардалд 4.8 сая, бараа үйлчилгээний бусад зардалд 2.1 сая, мөнгөн тэтгэмжид 35.0 сая, хөрөнгийн зардалд 11.8 сая төгрөгийг тус тус зарцуулж тайлант оны эцэст үлдэгдэлгүй байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Чулуут сумын Эрүүл мэндийн төв нь тайлант жилд ковид-19 халдварын эсрэг эрүүл мэндийн цогц тусламж үйлчилгээг нийт 421 хүнд үзүүлж ЭМДС-аас 443.6 сая төгрөгийн санхүүжилт нэхэмжилж гүйцэтгэлээр 359.1 сая төгрөг авч оны эцэст 84.5 сая төгрөгийн авлагатай тайлагнагдсан.

Чулуут сумын Эрүүл мэндийн төв нь 2021 онд ковид 19 цар тахалтай холбоотойгоор давхардсан тоогоор 936 иргэний ПСР-ийн шинжилгээг, 694 иргэний түргэвчилсэн шинжилгээг авч, 1-р тунд 2040, 2-р тунд 2461, 3-р 1074, 4-р тунд 20 иргэнд дархлаажуулалтын вакциныг, 624 иргэн хэвтэн эмчлүүлсэний 429 нь ковидоор хэвтэн эмчлүүлсэн байна. Харин үндсэн үйл ажиллагаагаар нийт 10864 иргэнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлсэний 7299 иргэнд урьдчилан сэргийлэх үзлэг байна.

Ковидын тархалтын оргил үе 2021 оны 9-11 сар нь ачаалал 4 дахин нэмэгдэж, нас баралтын 2 тохиолдол бүртгэгдсэн. Иймд дайчилгаагаар оюутнууд, тогооч авч ажилллуулсан байна.

Эрүүл мэндийн сайдын А/496, А/585 дугаар тушаалын дагуу коронавируст халдварын эрсдлээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээнд ажилласан нийт 25 эрүүл мэндийн ажилтанд нэг удаагийн мөнгөн тэтгэмжид 35.0 сая төгрөгийг олгосон байна.

3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллага нь жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан стратегийн зорилтуудыг хангахад чиглэсэн 11 үндсэн зорилтын хүрээнд 34 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилт 89.6 хувьтай байна.

Тайлант онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд 515.4 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөснөөс хэрэгжилт 99.3 хувийн биелэлттэй байна.

Аудитын явцад санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн дагуу дараах судалгааг авч үнэлэхэд Үүнд:

- Тус байгууллага нь тайлант онд 248.9 сая төгрөгийн бараа материал, 66.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг хандив тусламжаар авч тайланд бүрэн тусгасан байна.
- Тайлант жилд коронавируст халдвараар өвчилсөн иргэнийг гэрээр тусламж үйлчилгээ үзүүлээгүй, хэвтэн эмчлүүлсэн 429 иргэн байна.
- Байгууллагын жолооч Ж.Дансранпүрэв нь 2021 оны 11 сарын 01-ний өдрөөс эхлэн өндөр настны тэтгэвэрт тогтоолгож ажлаас чөлөөлөгдсөн байна.

Суудлын автомашин ашиглалтын хувьд: Тус байгууллагын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 2 тээврийн хэрэгсэлд 28.9 сая төгрөгийн шатахуун, 1.4 сая төгрөгийн сэлбэг хэрэгсэл зарцуулсан, орон тооны 1 жолоочтой, жолоочийн цалинд 14.0 сая төгрөгийг олгожээ.

Харин бусад судалгаанд хамаарах мэдээлэлгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж үр дүнг баримтжууллаа. /Local.audit.mn сайтад шивсэн/

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Чулуут сумын Эрүүл мэндийн төв нь тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс байршуулахаас 24 мэдээллийг хугацаа хоцроож мэдээллэсэн бөгөөд өмнөх аудитаар зөвлөмж өгөгдсөн байна.

Шийдвэрлэсэн нь: *Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-6.10-д заасан "төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ ..." гэсэн заалтыг хэрэгжүүлж зөрчлийг арилгуулах албан шаардлага хүргүүлээ.*

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай бүрэн нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх онд сахилгын шийтгэлтэй ажилтанд 0.2 сая төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон, төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлээс 2.7 сая төгрөгийн нөөц бэлтгэсэн зөрчилд төлбөрийн акт тогтоосон, дотоод хяналт, Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг, үндсэн хөрөнгөтэй холбоотой 3 зөвлөмж өгч биелэлтийг бүрэн хангуулсан.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Нэмэлт санхүүжилт, хандив тусламжийн зарцуулалтыг авч үзэх нь зүйтэй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 32.9 сая төгрөгийн зөрчил илэрсэнд 8.4 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 2.4 сая төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 22.1 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, анхан шатны баримттай холбоотой 1 зөвлөмжийг өглөө.

Залруулагдаагүй алдаа, зөрчлийн дүн 23.0 сая төгрөг нь тогтоосон ерөнхий материаллаг байдал 5.1 сая төгрөгөөс хэтэрсэн тул Хязгаарлалттай дүгнэлт өглөө.

4.1 Залруулсан алдаа

Санхүүгийн үр дүнгийн тайланд 8.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн элэгдлийг бодуулаагүй тайлагнасныг аудитын явцад залрууллаа.

4.2 Төлбөрийн акт

- Цалингийн давтан тооцооллоор 0.9 сая төгрөгийн илүү цагийн хөлсийг зөрүүтэй олгосон зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийг хэмнэлтийн Засгийн газрын 43 дугаар тогтоол болон Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", ЗГ-ын 382-р тогтоолын 2-р хавсралтын 2.2 дахь заалт "...илүү цагийн хөлсийг тодорхойлохдоо сарын цалин хөлсний хэмжээг тухайн сарын ажиллавал зохих цагт хувааж, нэг цагт ногдох цалин хөлсийг тооцож гаргана. Нэг цагийн цалин хөлсийг илүү ажилласан цагаар үржүүлж гарсан цагийг 1.5 дахин нэмэгдүүлж, илүү цагийн хөлсний хэмжээг тодорхойлно" гэсэн заалтуудтай нийцээгүй байна.

- Түлшний зарцуулагдаагүй үлдэгдэл 1.5 сая төгрөгийг өсөвт төвлөрүүлээгүй нүүрс бэлтгэсэн.

Энэ нь Төсвийг хэмнэлтийн Засгийн газрын 43 дугаар тогтоол болон Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 45.2-д "Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ" гэсэн заалтуудтай нийцээгүй байна.

4.3 Албан шаардлага

Тайланд жилд нэмэлт санхүүжилтаас Мед буян трейд ХХК-аас 22.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн худалдан авахдаа харьцуулалтын аргаар сонгон шалгаруулалт, тендер худалдан авалтыг зохион байгуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", ТБОНӨХБАҮХАТ хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-т "Засгийн газар нь барааны, ажлын, үйлчилгээний гэсэн ангилал тус бүрээр дараах босго үнийг тогтооно, 8.1.2 шууд худалдан авч болох бараа, ажил үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар, 33.2 ххарьцуулалтын аргыг дараах байдлаар төсөвт өртгийн дээд хязгаар, 33.2 Харьцуулалтын аргыг дараахь байдлаар хэрэглэнэ" 33 дугаар зүйлийн 33.2.1 үнийн санал ирүүлэх урилгыг энэ хуулийн 52.1.12, 53.5.4-т заасан худалдан авах ажиллагааны цахим системд зарлаж, үр дүнг тухай бүр бүрд мэдээлэх" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах албан шаардлага өгөх.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав.

Анхан шатны баримтын бүрдэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тээвэр шатахууны зардлыг нярвын тайлангаар хөөн шалгахад тээвэр шатахууны зарцуулалтанд бүртгэлээр тавих хяналт алдагсан буюу жолоочийн тооцооны хуудсыг хөтлөөгүй, шатахууныг нормоор хэтрэлт, хэмнэлтийг тооцоогүйтэй холбоотой 28.9 сая төгрөгийн зөрчил илэрлээ..

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5-т "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна", 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөж заавар"-ын, 4 "Хөнгөн тэрэг хэрэглэсэн албан тушаалтан хэдэн км явснаа хянаж гарын үсэг зурна. Тооцоог нягтлан бодогч хий, нийт дүнгээр түлш, шатахууны хэмнэлт, хэтрэлтийг гаргана" гэсэн заалтуудтай нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйл, Сангийн сайдын 347 дугаар тушаалын дагуу нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримтын бүрдлийг хангуулж ажиллах зөвлөмжийг өгч байна.

Зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 6 дугаар сарын 01 -ний өдрийн дотор ирүүлнэ үү.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

| Д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|--|-------------------------------------|----------------------|-------------|-----------|------------|---------------|------------|-----------------|-------------|----------|----------|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Санхүүгийн тайлангийн аудитын асуудал | | | | | | | | | | | |
| | Чулуут ЭМТ | 5 | 32.9 | 1 | 8.4 | 2 | 2.4 | 1 | 22.1 | 1 | 0 |
| | дүн | 5 | 32.9 | 1 | 8.4 | 2 | 2.4 | 1 | 22.1 | 1 | 0 |
| Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал | | | | | | | | | | | |
| | Чулуут ЭМТ | 1 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 1 | 0 | 0 | 0 |
| | дүн | 1 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 1 | 0 | 0 | 0 |
| | Нийт дүн | 6 | 32.9 | 1 | 8.4 | 2 | 2.4 | 2 | 22.1 | 1 | 0 |